



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 1/172

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 16 зүйлийн 16.2, 16.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Хэнтий аймгийн Хэрлэн суманд "Амгалан буян" эмийн сан, Хэнтий аймаг Баян-Овоо суманд "Алтан талын хишиг" эмийн санд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 04 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай тус тус шинээр олгосугай.

2. Дээрх эмийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаад/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 900